

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
217 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Эмнэлгийн тусламжийн бодлогын
газрын Анагаах ухааны инноваци,
технологийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн технологийн үнэлгээ
хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Ахлах түшмэл, ТЗ-5

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар 14210, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын 8
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээнд технологийн үнэлгээ, дүн шинжилгээг
хийх, бодлогын хэрэгжилтийн нэгдсэн удирдлага, зохицуулах чиг үүргийн хүрээнд
гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Салбарын хэмжээнд тусламж үйлчилгээнд технологийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх, бодлогын хэрэгжилтийн нэгдсэн удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг хийх;
2. Эрүүл мэндийн технологийн үнэлгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эрүүл мэндийн технологийн үнэлгээг нэвтрүүлэхэд салбаруудын үүрэг оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлж, чадавхыг бэхжүүлж, уялдаа холбоог хангах, зохицуулах;
3. Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, дүн шинжилгээг нотолгоонд суурилан хөгжүүлэх, дэмжих, зохицуулах;
4. Хууль, тогтоомж боловсруулах, зохицуулалт, тайлагналт, мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих;
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд технологи үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, инновац, технологийн чадавхийг хөгжүүлэх эрх зүйн баримт бичиг боловсруулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн бодлогын бичиг баримт батлагдсан байна.	Г, Х
	2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх дэвшилтэт технологи, инновацийн үйл ажиллагаанд технологийн үнэлгээг хийлгэх, төлөвлөх,	Төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийгдсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийн технологийн үнэлгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, холбогдох хороо зөвлөлөөр хэлэлцүүлэх;	Тэргүүлэх чиглэлийг тогтоож, холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.	Г
	2.Эрүүл мэндийн технологийн үнэлгээний оролцогч талуудыг тодорхойлж, тэдний чиг үүрэгтэй уялдуулах, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх;	Бусад салбарын оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэлийг хангасан байна.	Г, Т
	3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн болон зардлын үр дүн, аюулгүй байдал, үр ашгийн үнэлгээ (эрүүл мэндийн технологийн	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтэрсэн болон цаашид нэвтрүүлэх тусламж	Г, Х

	үнэлгээ)-г хийх, үнэлгээг нягтлан хянаж, санал боловсруулах, холбогдох зөвлөл, хороогоор хэлэлцүүлэх;	үйлчилгээний багцуудад эрүүл мэндийн технологийн үнэлгээг хийж, мэргэжлийн зөвлөл хороодоор хэлэлцүүлсэн байна.	
	4.Эрүүл мэндийн технологийн үнэлгээний үйл явцын удирдамж, гарын авлага боловсруулах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган олон талын оролцоог хангах;	Олон талын оролцоог хангасан, үнэн зөв арга зүй, мэдээлэл бүхий зөвлөмжийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухааны сүүлийн үеийн дэвшлийн талаар тогтмол мэдээлэл солилцох, судалгааны санаачлагуудыг дэмжихийн тулд их дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах, анагаахын судалгаа, мэдээлэл нотолгоонд суурилж эрүүл мэндийн технологийн үнэлгээ, дүн шинжилгээ хийх үйл явцыг дэмжих;	Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, дүн шинжилгээг эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, нотолгоог ашиглан, түүнд суурилан хийж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	2.Эрүүл мэндийн технологийн үнэлгээний үндсэн зарчим, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, үндсэн үйл явцын чиглэлээр бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч болон бусад оролцогч талуудыг нэгдсэн мэдээллээр хангах	Эрүүл мэндийн байгууллага, хуулийн этгээдийн оролцоог хангаж, мэдээлэл бодитой, хуульд нийцсэн байна.	Г
	3.Эрүүл мэндийн технологийн үнэлгээний тайлан, үр дүн зөвлөмжийг эцэслэн хэлэлцүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэх механизмыг бүрдүүлэх	Мэдээлэл нотолгоотой, нээлттэй, бодитой, хуульд нийцсэн байна.	Г, Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн баримтыг боловсруулах	Хууль тогтоомж, эрх зүйн баримтыг боловсруулахад оролцсон байна.	Г, Х
	2.Эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн чиглэлийн мэргэжлийн зөвлөл, хороодын үйл ажиллагааг эрүүл мэндийн	Эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн	Г, Т

	технологи үнэлгээний чиглэлтэй уялдуулах, хамтрах;	байна.	
5 дүгээр зорилтын хүрээнд	1.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна.	Г
	2.Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль, тогтоомжинд нийцсэн бодитой байна.	Г,Т
	3.Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих;	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
	4.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г,Т
	5.Нэгжид ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулалтад хяналт тавих.	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийсэн байна.	Х, Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	- анагаах ухаан /0912/; - эдийн засаг/ 0311/.		
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	- Төрийн албанд 6 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;	

		- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үйл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх, баримт бичиг боловсруулах; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ



Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогын газрын Анагаах ухааны инноваци, технологийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан тушаалтан;

	- Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА /Б.БАТБАЯР/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25.05.21 <u>Дугаар:</u> 217
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА..... /Д.ОЧИРБАТ/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	